

ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ

ҮНДЭСТЭН ДАМНАСАН АЮУЛ ЗАНАЛТАЙ ТЭМЦЭХ МОНГОЛ УЛС БА ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Н.Дөлгөөнбаатар

ДХИС-ийн Удирдлагын академийн 2022-7081 дүгээр дамжааны магистрант,
ахлах дэслэгч

Оршил

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг (цаашид ҮДЗБГХ гэх) нь дэлхий даяар энх тайван, хүний аюулгүй байдалд заналхийлж, хүний эрхийг зөрчин, улс орнуудын эдийн засаг, нийгэм, соёл, улс төр, иргэний хөгжлийг доройтуулж байна. ҮДЗБГХ нь мөнгө угаах, терроризм, мансууруулах бодисыг хууль бусаар хил нэвтрүүлэх, хүн худалдаалах гэмт хэрэг гэсэн төрөл бүрийн хэлбэрээр илэрч байдаг бөгөөд шинээр бий болсон зах зээлийн орон зайд дасан зохицож, гэмт хэргийн төрлүүдийг нэмэгдүүлж байдаг.¹

Нуугдмал хэлбэртэйгээр, улс орны хил хязгаарыг үл харгалзан үйлдэгдэж, аливаа соёл, нийгэм, хэл болон газар зүйн саад бэрхшээлийг давж, олон тооны оролцогчидтой байдаг учраас энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх нь нилээдгүй хүндрэл бэрхшээлийг дагуулдаг болно. НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн алба нь 2010 онд анх удаа ҮДЗБГХ-ийн аюулд үнэлгээ хийж, энэ нь “нийт хүн төрөлхтөнд нөлөөлөх аюул заналхийлэл” болсон байна гэж үзсэн байдаг.

ҮДЗБГХ “үндэстэн дамнасан” байдаг тул энэ төрлийн гэмт үйлдэл нь аль нэг улсын хил, хэл, соёлыг саадгүйгээр давж, гэмт хэргийн сүлжээг үүсгэх чадвартай байдаг онцлогтой юм.

ҮДЗБГХ нь хэл, соёл, нийгэм, газар зүйн хилийг даван үйлдэгдэж байдаг тул тууштай, олон улсын хүчин

чармайлтыг хамарсан хариу арга хэмжээ авахыг шаарддаг байна.

Монгол Улсад сүүлийн жилүүдэд хууль бусаар мансууруулах бодис, хар тамхи тараах, хэрэглэх, тээвэрлэх, дамжин өнгөрүүлэх, галт зэвсэг болон хүн худалдаалах, мөнгө угаах зэрэг зохион байгуулалттай нууц далд аргаар үйлдэгддэг, шинэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх болсон нь олон улсын чанартай үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргүүд үйлдэгдэх боломж өндөр байна.

ҮНДЭСТЭН ДАМНАСАН ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Үндэстэн дамнасан, нарын зохион байгуулалттай, голдуу нуугдмал хэлбэрээр нэг улсын хил хязгаараас улс орон дамжин, аливаа соёл, нийгэм хэл болон газар зүйн саад бэрхшээлийг давж, олон тооны оролцогчтой үйлдэгддэг нийгмийн хор аюул ихтэй гэмт хэргүүдийг үндэстэн дамнасан гэмт хэрэг гэж ойлгоно.

Үндэстэн дамнасан гэх нэр томьёо.

Хоёроос доошгүй бие даасан бүрэн эрхт улсын хилийг давж, үндэстэн дамнан үгсэн хуйвалдсан гэмт үйлдэл, гарсан тухайд хэрэглэгдэнэ. Хэрэглэгдэхүүн нь бараар, мөнгө, хүн, мэдээлэл бусад материаллаг болон материаллаг бус зүйлс байж болно.²

Үндэстэн дамнасан гэмт явдлын үндсэн төрлүүд /НҮБ/

1. Мөнгө угаах
2. Алан хядах ажиллагаа
3. Соёлын өв, үнэт зүйлсийн

хулгай

¹ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Бодлогын судалгаа, дүн шинжилгээ. 2017.05 сар

² Ц.Дарьжав. “Цагаан тахал”. УБ., 2011. 6 дахь тал.

4. Оюуны өмчийн хулгай
5. Галт зэвсгийн хууль бус худалдаа
6. Нисэх онгоц хулгайлах
7. Далайн дээрэм
8. Газар доорх тээврийн хэрэгслийг эзлэн авах
9. Даатгалыг залилах
10. Компьютерын гэмт хэрэг
11. Экологийн гэмт хэрэг
12. Хүн худалдаалах
13. Хүний эд эрхтэн худалдаалах
14. Хар тамхины хууль бус худалдаа
15. Хуурамч дампуурал
16. Ил бизнест нэвтрэх
17. Олон нийтийн, намын зүтгэлтэн, сонгууль, этгээдийг хахуулах, худалдан авах

Үндэстэн дамнасан гэмт явдлын онцлог шинж

1. “Үндэстэн дамнасан” байдаг тул энэ төрлийн гэмт үйлдэл нь аль нэг улсын, хэл соёлыг сайдгүйгээр давж, гэмт хэргийн сүлжээг үүсгэх чадвартай.
2. Зохион байгуулалттай үйлдэгддэг тул зогсонги байдалд өөрийн тогтнодоггүй /тасралтгүй байх/ бөгөөд шинэ гэмт хэргүүд бий болж, гэмт хэргийн сүлжээний харилцаа холбоо улам бүр нарийсч тухай бүрд шинэ нөхцөл байдалд дасан зохицох чадвар өндөр.
3. Асар өргөн газар нутгийг хамран, хэл, соёл, нийгэм, газар зүйн хилийг даван үйлдэгддэг.
4. Нийтийн хор аюул ихтэй.
5. Нууц далд хэлбэртэй.
6. Гэмт бүлэглэлүүдэд гэсэн бүтэц, зохион байгуулалт голлох чиглэл, дүрэм журамтай.
7. Зорилгодоо хүрэхийн тулд хээл хахууль өгөх, хүч хэрэглэх, зэрэг арга хэрэгслийг ашигладаг.

8. Тусгай субъект – хил гааль, экологийн хяналтын ажилтан, даатгалын, аялал жуулчлалын гэх мэт.

Үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх тухай эрх зүйн баримт бичиг буюу олон улсын эрх зүйн хэм хэмжээ

Улс дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын эрх зүйн үндсийг хөндөхийн тулд энэ талаарх олон улсын гэрээ, конвенц, баримт бичгийг судлах зайлшгүй шаардлага тулгарч байна. Манай улсад энэ чиглэлээр дагнасан судалгаа шинжилгээ одоо хүртэл хийгдээгүй байгааг тэмдэглэхгүй өнгөрч болмооргүй байна.

Улс дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн үндсийг тогтоосон олон улсын эрх зүйн хэм хэмжээг нийтлэг ба тусгай хэм хэмжээ гэж ангилж болох юм.

Нийтлэг хэм хэмжээ: Ийм хэм хэмжээнд НҮБ-аас тогтоосон улс дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх ерөнхий үндэслэл, зохион байгуулалтыг бэхжүүлсэн хэм хэмжээг хамааруулж болохоор байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2000 оны 11 дүгээр сарын, 15-ны өдрийн тогтоолоор батлагдсан “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц” нь дэлхийн |хэмжээнд зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх ерөнхий үндэслэлийг заасан хамгийн гол чухал олон улсын эрх зүйн үндсэн эх сурвалж мөн. Энэхүү конвенцын үндсэн зорилго нь улс дамнасан зохион байгуулалттай гэмт явдлаас улам бүр үр нөлөөтэй урьдчилан сэргийлэх түүнтэй тэмцэх үйлсийн хамтын ажиллагаанд тус дөхөм үзүүлэх явдалд оршино.¹

Энэхүү НҮБ-ын конвенц нь зохион байгуулалттай гэмт бүлгийн оролцоотой, мөнгө угаах, авлигатай

¹ Б.Алтанбагана. “Улс дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг”, УБ.2013. 45 дахь тал.

² Б.Алтанбагана. “Улс дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг”, УБ.2013. 46 дахь тал.

тэмцэх тодорхой арга хэмжээг багтаасан, конвенцод заасан гэмт хэргээс урьдчил. сэргийлэх, мөрдөх ба эрүүгийн мөшгөлт явуулах үйл ажиллагаа. зохицуулсан олон улсын эрх зүйн нэн чухал баримт бичиг мөн.

Гэмт хэрэгт тооцох: Тус конвенцоор оролцогч улс бүр “Зохион байгуулалттай гэмт бүлэгт оролцохыг гэмт хэрэгт тооцох (5 дугаар зүйл), “Гэмт хэргийн орлогыг угаахыг гэмт хэрэгт тооцох (6 дугаар зүйл), “Авлигыг гэмт хэрэгт тооцох” (8 дугаар зүйл), “Шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд саад учруулахыг гэмт хэрэгт тооцох” (23 дугаар зүйл) үүрэг авсан байна. Түүнчлэн оролцогч улсуудаас “Мөнгөн хөрөнгийг угаахтай тэмцэх арга хэмжээ” (7 дугаар зүйл), “Авлигын эсрэг арга хэмжээ” (9 дүгээр зүйл) авахыг заажээ.

Тус конвенцыг судалж үзэхэд оролцогч улсуудад дараах дөрвөн төрлийн үйлдлийг гэмт хэрэгт тооцохыг үүрэг болгожээ. Үүнд:

1.Зохион байгуулалттай гэмт бүлэгт оролцох;

2.Гэмт хэргийн орлогыг угаах;

3.Авлига (коррупци);

4.Шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд саад учруулах

Манай улсын хувьд эдгээр хэргийг Эрүүгийн хуульдаа гэмт хэрэгт тооцсон байна.

Тусгай хэм хэмжээ. Улс дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын эрх зүйн тусгай хэм хэмжээ нь тодорхой төрлийн хэргийн талаар НҮБ-аас батлан гаргасан тодорхой төрлийн гэмт хэргийн талаарх конвенцууд юм. Ийм конвенц гэвэл,¹

- Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын нэмэлт протокол (1999);

- Хүүхдийн эрхийн тухай конвенц (1989);

- Авлигын эсрэг НҮБ-ын конвенц (2003);

- Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай олон улсын конвенц (1999);

- Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенц (1963);

- Хүн барьцаанд авахын эсрэг олон улсын конвенц;

- НҮБ-ын олон улсын худалдааны гүйлгээнд коррупци ба хахуультай тэмцэх тухай тунхаглал (1996);

-Боолчлол, боолын худалдааг хориглох тухай конвенц (1926);

-Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс, заншлыг устгах тухай нэмэлт конвенц (1956);

-Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц (1961);

-Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц (1971),

-Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенц (1971);

-Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол (2000) зэрэг олон конвенцыг нэрлэж болно.

Монгол Улс дахь үндэстэн дамнасан гэмт хэргийн өнөөгийн байдал.

Мэдээлэл нэгтгэн боловсруулах газраас гаргасан статистик мэдээллээс үзэхэд дээрх төрлийн гэмт хэргүүд бүртгэгдсэн байх ба Терроризм, Терроризмыг санхүүжүүлэх, Тэсэрч дэлбэрэх болон түргэн шатамхай бодисыг агаарын хөлөгт хууль бусаар авч явах, Олон улсын нислэгийн журам зөрчих, Агаарын хөлөг авч зугтаах гэмт хэргүүд бүртгэгдээгүй статистик мэдээ гарсан байна.

Эрүүгийн цагдаагийн албанаас авсан мэдээлэл

Үндэстэн дамнасан олон улсын шинжтэй гэмт хэрэгтэй одоогийн байгаа цагдаагийн байгууллагын бүтэц, орон тоо, зохион байгуулалтын тогтолцоо хангалттай бус байна. 2012 онд Монгол Улсад зохион байгуулалттай онц хүнд гэмт хэрэгтэй тэмцэх цагдаагийн нэгж болох УМБГ шинэ бүтэц зохион байгуулалтад орж, Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг мөрдөх хэлтэс, Онц хүнд, зохион байгуулалттай гэмт хэрэг мөрдөх хэлтэст Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой хэрэг мөрдөх, Хүн худалдаалах гэмт хэрэг мөрдөх тасаг байгуулсан.

ЦЕГ-ын даргын тушаалаар 2017.06.30-ны өдрөөс ЭЦА-ны III хэлтсийн бүтцэд Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасаг байгуулагдан, тасгийн дарга 1, эрүүгийн ахлах мөрдөгч 2, эрүүгийн мөрдөгч 2 орон тоо нэмэгдэн нийт 5 алба хаагчийн орон тоотой ажиллаж байна.

Эрүүгийн цагдаагийн албанаас хийсэн онцлог ажлаас дурдвал:

Гэмт этгээдүүд нь цахим ертөнц буюу нийгмийн цахим сүлжээ **Facebook, twitter, yahoo messenger, unequi.mn** гэх мэт сошиал сайтуудыг ашиглаж садар самууныг сурталчлах, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, гэмт хэргийн хохирогчдыг элсүүлэх явдал, ялангуяа өсвөр насны охид, хөвгүүдэд садар самуун явдалтай холбоотой сэдэл өгөх, амар хялбар аргаар мөнгө олох боломжтой мэт санагдуулах сөрөг мэдээллийг интернэт орчин дахь хяналтгүй байдлыг далимдуулан ашиглаж байгаад хяналт тавин ажиллаж байна.

Нийт 52 саун массажны газар, 4 караоке бааранд бэлгийн мөлжлөгийн зорилгоор бусдыг худалдаалах, бусдыг биеэ үнэлэхийг зохион байгуулж буй үйлдлийг илрүүлэн хэрэг бүртгэлтийн 6 хэрэг, зөрчлийн 42 хэрэг нээж харьяа дүүргийн Цагдаагийн хэлтэстэй хамтран шалгасан.

Дээрх 52 газрын 5 нь гоо сайхан, массажны үйл ажиллагаа явуулах

гэрчилгээтэй, бусад 47 газар нь ямар нэгэн зөвшөөрөлгүй.

Шалгалтаар Баянгол дүүрэгт байрлах 26, Баянзүрх дүүрэгт байрлах 12, Сонгинохайрхан дүүрэгт байрлах 2, Сүхбаатар дүүрэгт байрлах 3, Чингэлтэй дүүрэгт байрлах 7, Хан-Уул дүүрэгт байрлах 2 газрыг тогтоосон.

- ЦЕГ, НЦГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтран MYONT, EAGLE, SBN, TV10, ROYAL телевизүүдтэй 6 удаагийн шөнийн сурвалжилга

- SBN телевизийн “Сэрэмжлүүлэг”, MYONT-ийн “Сүүдэр”, EAGLE TV-ийн “Бодит байдал”, TV10 телевизийн “Дохио”, ROYAL телевизийн “Малчин”, “Халуун цэг” нэвтрүүлгүүд

- Zarig.mn сайтад “Гулгаа массаж”, Zалуu.com сайтад “Саун массаж”, Gogo.mn сайтад “Биеэ үнэлэгч”, Zindaa.mn сайтад “Караоке нэрийн доор биеэ үнэлэлж байна” зэрэг нийтлэл, мэдээллүүд

- FM 100,7, FM 107.5, FM 102.5, FM 96.5, FM 106.5 зэрэг радиод ярилцлага

- MYONHT-ийн “Цагийн хүрд”, “Чухал сэдэв”, “Эрх зүйн хөтөч” хөтөлбөр, TV10 телевизийн “Мэдээллийн цаг” хөтөлбөр, VTV телевизийн “Гэр мэдээллийн хөтөлбөр”-т тус тус оролцож мэдээлэл өгсөн.

- **WWW.MSGZAR.MN** сайтын 151999 тусгай дугаараар садар самууныг сурталчлах, биеэ үнэлэхэд бусдыг зуучлах, зохион байгуулах гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй заруудыг байнга олон нийтэд хүргэж байсныг Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтран Харилцаа холбооны зохицуулах хороонд 2018.02.08-ны өдрийн 9/825 дугаартай

албан бичгээр хандан үйл ажиллагааг нь зогсоолгосон.¹

Дотоод нөхцөл байдал:

Манай улсын тухайд БНХАУ-ын ШУӨЗО-ны хил залгаа нутагт үйл ажиллагаа явуулдаг Исламын шашны ваххабист үзэлтэй байгууллагуудын зарим гишүүд Монгол Улсад нэвтэрсэн тохиолдлууд бүртгэгдэж байсан. Монгол Улсын хил нэвтэрч түр болон удаан хугацаагаар оршин сууж байсан дээрх ваххабист үзэлтэй байгууллагуудын зарим гишүүдийг хяналтад авч эрсдэлээс сэргийлэх, саармагжуулах арга хэмжээг зохион байгуулан ажилладаг.

Монгол Улс дахь терроризмын нөхцөл байдал

Монгол Улсад Исламын шашны хэт үзэл, террорист үйл ажиллагаа явуулдаг байгууллага, иргэн байхгүй гэж дүгнэж болох боловч нэг бүс нутагт байрладаг терроризмын эрсдэл өндөр улсуудын иргэдтэй хэл, соёл, шашин шүтлэг адил, газар зүйн байрлалын хувьд ойр оршин суудаг манай улсын зарим иргэд террорист байгууллагад гишүүнээр элсэх, дэмжих үйл ажиллагаанд оролцож болзошгүй хандлагатай байна.

Монгол Улсад террор халдлага үйлдэгдэж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, нөхцөл байдал

Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан сүүлийн үед жагсаал цуглаан, эсэргүүцлийн арга хэмжээ тогтмол зохион байгуулагдаж, түүнд оролцох иргэдийн тоо өсөх хандлагатай байна.

Иргэд эвлэлдэн нэгдэж үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдэлж байгаа боловч зарим нэг жагсаал цуглаан, эсэргүүцлийн арга хэмжээ иргэдийг бослого тэмцэлд уриалан дуудсан, олон нийтийг эмх замбараагүй байдалд өдөөн турхирсан шинжтэй зохион байгуулагдах болсон.

Монгол Улсад Исламын шашны хэт үзэл, террорист үйл ажиллагаа явуулдаг байгууллага, иргэн байхгүй гэж дүгнэж болох боловч нэг бүс нутагт байрладаг терроризмын эрсдэл өндөр улсуудын иргэдтэй хэл, соёл, шашин шүтлэг адил, газар зүйн байрлалын хувьд ойр оршин суудаг манай улсын зарим иргэд террорист байгууллагад гишүүнээр элсэх, дэмжих үйл ажиллагаанд оролцож болзошгүй хандлагатай байна.

Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан сүүлийн үед жагсаал цуглаан, эсэргүүцлийн арга хэмжээ тогтмол зохион байгуулагдаж, түүнд оролцох иргэдийн тоо өсөх хандлагатай байна.

Үүсээд буй нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд төр, засгаас хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээ, шийдвэрт хөндлөнгөөс нөлөөлөх, шахалт үзүүлэх гэсэн далд санаа зорилгоо:

- ард түмний эрх ашиг,
- эх оронч, үндсэрхэг үзэл,
- нийгэм эдийн засгийн хүндрэл,
- байгаль орчин,
- уул уурхай,
- утаа,

- оффшор гэх мэт нийгэмд тулгамдсан асуудлаар халхавчлан гадны болон улс төр, бизнесийн салбарын захиалга, санхүүжилтээр улс төрийн нам, иргэний хөдөлгөөн, хэт үндсэрхэг үзэлтэй бүлгүүд жагсаал цуглаан, эсэргүүцлийн арга хэмжээг тасралтгүй зохион байгуулж, цахим орчинд иргэдийг мэдээллээр төөрөгдүүлэн, нийгэмд санаатайгаар эмх замбараагүй байдал үүсгэхийг оролдох болсон.

Мөн олон нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал цуглаан зохион байгуулахаас илүүтэйгээр тодорхой сэдэв, нийгмийн эмзэг асуудлын талаар захиалгат нэвтрүүлэг, нийтлэл бэлтгэн

¹ Цагдаагийн ерөнхий газрын, Мэдээлэл нэгтгэн боловсруулах газрын 2012-2017 оны гэмт хэргийн зүйлийн мэдээ.

хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, телевиз, интернэт сайт, Facebook, Twitter зэрэг цахим орчныг ашиглан иргэдийн санаа бодол, массын сэтгэл зүйд нөлөөлөх, пи-ар хийх, “Зохиомол уур амьсгал бүрдүүлэх” аргыг өргөнөөр ашиглах болсон бөгөөд цаашид энэ байдал улам дэлгэрэх хандлагатай байна.¹

Үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх талаар олон улсын хамтын ажиллагаа.

Хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа:

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2000 оны 11 дүгээр сарын, 15-ны өдрийн тогтоолоор батлагдсан “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц”-оор Оролцогч улсуудын хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд онцгой анхаарал тавьж, энэ чиглэлийн зохицуулалтыг буй болгожээ.

1. Конвенцын 26 дугаар зүйлд Оролцогч улс бүр зохион байгуулалттай гэмт бүлэгтэй холбогдсон хэргийг мөрдөх ба нотлох зорилгоор эрх хэмжээ бүхий байгууллагад ашигтай мэдээлэл өгнө.

а. Зохион байгуулалттай гэмт бүлгийн шинж, гишүүдийн бүрэлдэхүүн, бүтэц, оршин байгаа газар ба үйл ажиллагааны тухай мэдээ, сэлт

б. Зохион байгуулалттай гэмт бүлгийн олон улсын хэлхээ холбоо, бусад бүлгүүдтэй холбогдох мэдээ, сэлт

в. Зохион байгуулалттай бүлгийн үйлдсэн буюу үйлдэж болзошгүй гэмт хэргийн тухай мэдээ, сэлт

2.Эрх бүхий байгууллагаас зохион байгуулалттай гэмт бүлгийн нөөц буюу гэмт хэргийн орлогыг үгүй болгоход тус дөхөм болсон тодорхой бодит туслалцаа

Конвенцын 27 дугаар зүйлд хууль сахиулах байгууллагуудын хоорондын

хамтын ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг заасан. Үүнд:

1.Энэхүү конвенцод заасан гэмт хэрэг ба хэрэв сонирхогч Оролцогч улс шаардлагатай гэж үзвэл бусад төрлийн гэмт үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийг түргэн шуурхай солилцох, зохих эрх бүхий байгууллага, тусгай албадууд хоорондоо хэлхээ холбоог тогтоох ба бэхжүүлэх

2.Энэхүү Конвенцод заасан гэмт хэрэгтэй холбогдуулан мөрдөлт явуулахдаа бусад Оролцогч улстай дараах нөхцөл байдлыг илрүүлэх зорилгоор хамтран ажиллана. Үүнд:

а.Тийм гэмт хэрэг үйлдэхэд оролцсонд сэжиглэгдэж буй этгээдийн хувийн байдал, оршин байгаа газар ба үйл ажиллагаа буюу хамааралтай бусад этгээдийн байгаа газар.

Б.Гэмт хэргийн орлогын буюу тийм гэмт хэрэг үйлдсэний үр дүнд олж авсан эд хөрөнгийн шилжүүлэлт

в.Тийм гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан буюу зориулагдсан эд хөрөнгө, тоног төхөөрөмж, бусад хэрэгсэл

3.Шаардлагатай тохиолдолд шинжилгээ буюу мөрдөлтийн зорилгоор зайлшгүй зүйл буюу зайлшгүй тооны эд юмсыг өгөх

4.Оролцогч улсуудын эрх бүхий байгууллага, албадын хоорондын үйл ажиллагааг үр ашигтай уялдуулан зохицуулахад тус дөхөм үзүүлэх ба ажилтнууд, бусад шинжээчдийн солилцоог урамшуулах²

5.Шаардлагатай тохиолдолд маршрут, тээврийн хэрэгсэл, түүнчлэн хувийн байдлын хуурамч үнэмлэх ашиглах, өөрчилсөн буюу хуурмагласан бичиг баримт буюу тэдгээрийн үйл ажиллагааг нуусан бусад хэрэгслийг оролцуулан зохион байгуулалттай гэмт бүлгээс хэрэглэсэн тодорхой хэрэгсэл ба аргын тухай

¹ Цагдаагийн ерөнхий газрын, Мэдээлэл нэгтгэн боловсруулах газрын 2012-2017 оны гэмт хэргийн зүйлийн мэдээ.

² Б.Алтанбагана. “Улс дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг”, УБ.2013. 50 дахь тал.

мэдээллийг I I Оролцогч бусад улстай солилцох.

6. Шаардлагатай тохиолдолд энэхүү Конвенцод заасан гэмт хэргийг цаг тухайд нь илрүүлэх зорилгоор авсан захиргааны ба бусад арга хэмжээний мэдээллийг солилцох ба уялдуулан зохицуулах.

Энэхүү конвенцыг бодитой хэрэгжүүлэх зорилгоор Оролцогч улсууд хууль сахиулах байгууллагуудын шууд хамтын ажиллагааны хоёр талын буюу олон талын хэлэлцээр буюу тохиролцоо байгуулах ба ийм хэлэлцээр буюу тохиролцоо байгаа тохиолдолд өөрчлөлт оруулна. Сонирхогч, Оролцогч улсуудын хооронд ийм хэлэлцээр буюу тохиролцол байхгүй бол оролцогч улсууд энэхүү конвенцын тус конвенцод заасан гэмт хэргийн хувьд хууль сахиулах байгууллагуудын хоорондын харилцан хамтын ажиллагааны үндэс гэж үзэж болно.

Дүгнэлт

Үндэстан дамнасан гэмт явдлын шалтгаан, нөхцөлийн судалгаа, тэмцлийн практикаас харахад мансуурлаас үүдэлтэй гэмт хэрэгтэй тэмцэхэд нэн түрүүнд хууль сахиулах байгууллага шийдвэрлэх үүрэгтэй болох нь тодорхой байна.

Монголын нийгэмд бодитой аюул учруулж болохуйц түвшинд хүрээд байгаа мансуурал, түүнтэй холбоотой сөрөг үр дагавар, гэмт хэрэгтэй тэмцэх, тухайлбал, илрүүлэх таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд тагнуул, цагдаа, прокурор, авлигатай тэмцэх газар, гааль, хил хяналт болон мэргэжлийн хяналтын байгууллагууд болон төрийн бус байгууллагуудын харилцан үр ашигтай, хамтын ажиллагаа нэн чухал.

НҮБ-ын “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг Конвенц”-ийг дэлхийн олон улс дэмжин соёрхон баталснаар үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт

хэргийн эсрэг арга хэмжээ авах үүрэг хүлээсэн.¹

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцод Монгол Улс өөрийн орны геополитикийн онцлогийг харгалзан үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор 2007 онд нэгдэн орсноор олон улсын хамтын ажиллагааны хүрээнд энэхүү төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх боломж бүрдсэн.

Хууль сахиулах байгууллагын мэдээллийн орчныг илүү боловсронгуй болгох зайлшгүй хэрэгцээ, шаардлага байгаа нь энэхүү гэмт хэргийн илрүүлэлт цаг хугацаагаар хэмжигддэг онцлогтой.

Гэмт хэргийн талаарх мэдээллийг дамжуулах хурдыг сайжруулах, нөгөө талаар Прокурор, Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Татвар, Гааль, Хил хамгаалах, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Монгол банк, Авто тээврийн газар зэрэг байгууллагуудтай нэгдсэн сүлжээнд холбогдон мэдээлэл авах техникийн нөхцөлийг бүрдүүлж, мэдээллийн нэгдсэн санг өргөн цар хүрээтэй ашиглах шаардлагатай юм.

Өнөөгийн мөрдөн байцаах албаны бүтцэд цаг үеийн хандлагыг дагасан зарим төрлийн нэмэлт өөрчлөлт, зохион байгуулалтыг хийх шаардлагатай байгаа нь статистик тоо баримт болон нийгмийн хүчин зүйлээр тодорхойлогдож байгаад дүгнэлт хийх шаардлагатай. Тухайлбал, Мэдээллийн аюулгүй байдлын эсрэг, Экологийн аюулгүй байдал, Хөрөнгийн зах зээл, санхүү биржийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэн энэ чиглэлээр төрөлжүүлэн ажиллуулах шаардлага бидний өмнө тулгараад байна гэж үзэж байна.

Эх сурвалжийн жагсаалт

¹ Hans-Jorg Albrecht. The Containment of Transnational Organized Crime. Freiburg i. BR. 2002

/Comments on the UN convention of December 2000/ pg 1

- Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын эрх зүйн хэм хэмжээ.

- Б.Алтанбагана. “Улс дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг”., УБ.2013

- Ц.Дарьжав. Б.Сосорбарам. “Цагаан тахал”., УБ.2011.

- Hans-Jorg Albrecht. The Containment of Transnational Organized Crime.Freiburg i. BR.2002 /Comments on the UN convention of December 2000/ pg 1

Хавсралт 1

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТ

Үндэстэн дамнасан гэмт явдал Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжид тусгагдсан байдал.

2002 оны Эрүүгийн хууль	2015 оны Эрүүгийн хууль
- Хүний цус, эд, эрхтэнг хууль бусаар авах 101 - Хүн хулгайлах 108 - Хүнийг барьцаалах 112 - Хүн худалдаалах 113 - Садар самууныг сурталчлах 123 - Мөнгө угаах 166-1 - Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх 175 - Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, онцгой албан татварын тэмдгийг хуурамчаар үйлдэх, ашиглах, борлуулах 176 - Терроризм 178-1 - Терроризмыг санхүүжүүлэх 178-2 - Тэсэрч дэлбэрэх болон түргэн шатамхай бодисыг агаарын хөлөгт хууль бусаар авч явах 184 - Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах буюу хордуулах, цацраг идэвхт, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх 188 - Олон улсын нислэгийн журам зөрчих 224 - Агаарын хөлөг авч зугтаах 225 - Хээл хахууль авах 268	- Хүн худалдаалах 13.1 - Хүн хулгайлах 13.2 - Хүн барьцаалах 13.3 - Хүний цус, эд, эрхтэнг хууль бусаар авах 15.3 - Хүүхэд хулгайлах 16.6 - Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх 18.5 - Мөнгө угаах 18.6 - Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцоог хуурамчаар бэлтгэж ашиглах 18.7 - Зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулах, түүнд элсэх 20.3 - Мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах 20.7 - Мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангах 20.8 - Террор үйлдэх 29.8 - Террор үйлдэхэд бэлтгэх 29.9 - Террор үйлдэхийг санхүүжүүлэх 29.10



Хавсралт 2


ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

д/д	Он Эрүүгийн хуулийн зүйл	2012 Нийт	2013 Нийт	2014 Нийт	2015 Нийт	2016 Нийт	2017 Нийт



1	Хүний цус, эд, эрхтэнг хууль бусаар авах 101	1					
2	Хүн хулгайлах 108		2			1	3
3	Хүнийг барьцаалах 112	2		2	3	3	
4	Хүн худалдаалах 113	9	10	8	6	3	10
5	Садар самууныг сурталчлах 123	4		1	1		
6	Мөнгө угаах 166-1		3	2	5	1	
7	Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх 175	66	98	69	42	40	57
8	Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, онцгой албан татварын тэмдгийг хуурамчаар үйлдэх, ашиглах, борлуулах 176	13	63	263	413	160	73
9	Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах буюу хордуулах, цацраг идэвхт, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх 188	8	2	2	6	5	1
10	Хээл хахууль авах 268	16	12	24	32	47	26

Хавсралт 3





Хавсралт 4



Хавсралт 5

